**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 11 өдөр Дугаар А/101 Чойр

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээдийг орон нутагт бүртгэж, зөвшөөрөл олгох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга |
| Гишүүд: | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| | Аймгийн Татварын газрын дарга |
| | Аймгийн Цагдаагийн хэлтсийн Эдийн засгийн ахлах мөрдөгч |
| Нарийн бичгийн дарга: | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн |

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (У.Занабазар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Г.БАТСУУРЬ

4212400237